

2019 ОНД ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Б. Түвшинтөгс /Эдийн засгийн ухааны доктор/
Эдийн засгийн судалгаа эрдэм, шинжилгээний хүрээлэн

Агуулга

1. Монголын үндэсний баялгийн сангууд ба тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөө
2. Уул уурхайн бирж байгуулах боломж
3. Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын судалгааны тойм
4. Тогтвортой хөгжил ба уул уурхай

Монголын үндэсний баялгийн сангууд ба тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөө

- Өмнөх судалгаануудад (“Төсвийн орлогын менежмент”) ТТБТХ, түүнд тусгасан дөрвөн тусгай шаардлагуудын эдийн засаг дахь нөлөөллийг үнэлсэн.
- Энэхүү судалгаанд баялгийн сангуудын эдийн засаг дахь нөлөөллийг үнэлэв
- Зорилго: ТТБС ба ИӨС-ийн эдийн засаг дахь нөлөөллийг үнэлэх
- Арга зүй: Динамик Тооцоолох Ерөнхий Тэнцвэрийн (CGE) Загвар ашиглан 2019-2040 он хүртэлх эдийн засгийн таамаглал боловсруулсан
- Симуляцын хувилбарууд:
 - Суурь: ТТБС болон ИӨС аль аль нь байхгүй
 - Хувилбар 1: Зөвхөн ТТБС байх
 - Хувилбар 2: Зөвхөн ИӨС байх
 - Хувилбар 3: ТТБС болон ИӨС хоёулаа байх

Уул уурхайн бирж байгуулах боломж

- “Уул уурхайн салбарын маркетинг ба борлуулалт” суурь судалгаагаар манай улсын ашигт малтмалын экспорт дахь бэрхшээлүүдийг бууруулах нэг шийдэл нь нэгдсэн худалдааны платформ эсвэл уул уурхайн бирж байгуулах байж болох юм гэж дүгнэсэн
- Зорилго: Уул уурхайн бирж болон худалдааны платформын бусад хувилбарыг байгуулахад шаардлагатай нөхцөлүүдийг судлах
- Арга зүй: Тойм судалгаа ба салбарын гол мэргэжилтнүүдтэй ярилцлага хийсэн

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын судалгааны тойм

- ГШХО нь эдийн засгийн өсөлтөд чухал үүрэгтэй төдийгүй худалдааны эргэлт, нийгмийн хөгжилд өндөр хувь нэмэр оруулдаг
- Зорилго: Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахад анхаарах зүйлс
- Арга зүй: CGE загварчлал ба тойм судалгаа
- Цуврал судалгаанууд:
 - Суурь судалгаа: ГШХО-ын хэлбэлзлийн шалтгаан, эдийн засгийн үр нөлөө, ГШХО-ыг татахад анхаарах зүйлс
 - Нэмэлт судалгаа 1: Чили ба Монгол улсын харьцуулсан шинжилгээ, худалдааны нөхцөл
 - Нэмэлт судалгаа 2: Монгол, Казахстан, Перу болон Замби улсын хөрөнгө оруулалтын орчны харьцуулсан шинжилгээ
 - Нэмэлт судалгаа 3: Маргаан шийдвэрлэлт, арбитраж

Тогтвортой хөгжил ба уул уурхай

- Байгалийн баялаг нь шавхагдах нөөц тул уул уурхайн салбарын эдийн засгийн үр өгөөжийг урт хугацааны тогтвортой хөгжилд чиглүүлэх нь чухал юм. Энэхүү судалгаагаар Монгол Улсын уул уурхайн салбарын тогтвортой хөгжилтэй холбоотой асуудлуудыг авч үзсэн.
- Зорилго: Уул уурхайн салбарын тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийг үнэлэх
- Арга зүй: Тойм болон кейс судалгаа
- Байгаль орчин, хөгжлийн олон улсын хүрээлэнгийн тодорхойлсон тогтвортой хөгжлийг тодорхойлох дөрвөн хүрээ:
 - Эдийн засаг (макро эдийн засаг, гадаад худалдаа, төсөв гэх мэт)
 - Нийгэм (боловсрол, ажил эрхлэлт, технологи)
 - Байгаль орчин (уул уурхайн салбарын нэмүү өртгийн сүлжээ дэх байгаль орчны асуудлууд, нөлөөллийн үнэлгээ)
 - Засаглал (бодлогын хүрээ, компанийн засаглал)